

Мэргэшлийн зэрэг олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмаар мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын хэрэгжилтийг зохицуулна.
- 1.2. Эрүүл мэндийн ажилтанд олгох мэргэшлийн зэргийн чиглэл нь Эрүүл мэндийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний баталсан мэргэшлийн чиглэл, индексийн дагуу байна.

Хоёр. Мэргэшлийн зэргийн удирдлага, зохион байгуулалт

2.1. Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- 2.1.1. мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааны хууль эрх зүйн орчинг сайжруулах, бодлогыг тодорхойлох;
- 2.1.2. эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- 2.1.3. мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Эрүүл мэндийн хөгжлийн төвд чиглэл, заавар өгөх, хяналт тавьж ажиллах.

2.2. Эрүүл мэндийн хөгжлийн төв нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- 2.2.1. мэргэжлийн нийгэмлэг, холбооны эрх сунгуулах, шинээр эрх хүссэн хүсэлтийг тухайн жилийн нэгдүгээр сард багтаан хэлэлцэж, шийдвэрлэх;
- 2.2.2. мэргэшлийн зэргийн шалгалтыг зохион байгуулах мэргэжлийн нийгэмлэг, холбоонд эрх олгох, цуцлах асуудлыг хэлэлцэж, 3 жилийн хугацаагаар цахим гэрчилгээ олгох;
- 2.2.3. мэргэшлийн зэргийн шалгалт зохион байгуулах эрх олгосон, эрх шинээр хүссэн мэргэжлийн нийгэмлэг, холбоонд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;
- 2.2.4. мэргэшлийн зэрэг олгохтой холбоотой үйл ажиллагааг зохицуулах нэмэлт зааврыг төвийн захирлын шийдвэрээр баталгаажуулж, хэрэгжилтийг хангах;
- 2.2.5. шаардлага хангасан мэргэжлийн нийгэмлэг, холбоо, салбар зөвлөл байхгүй тохиолдолд мэргэшлийн зэргийн шалгалт зохион байгуулах;
- 2.2.6. мэргэжлийн нийгэмлэг, холбооноос зохион байгуулсан мэргэшлийн зэргийн шалгалтын тайланг тухайн жилийн арваннэгдүгээр сард багтаан хэлэлцэж шийдвэрлэх;
- 2.2.7. мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх;
- 2.2.8. мэргэшлийн зэрэг олгосон, хүчингүй болсон тухай төвийн захирлын тушаал гарсан нөхцөлд ажлын 3 хоногт багтаан “Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн сан”-д мэдээллийг оруулах;
- 2.2.9. мэргэшлийн зэрэгтэй холбоотой цахим мэдээний сангийн бүрдэл, мэдээллийн аюулгүй байдалд хяналт тавьж, “Эрүүл мэндийн ажилтны

нэгдсэн бүртгэлийн сан"-гийн тогтвортой үйл ажиллагааг ханган, шаардлагатай хөгжүүлэлтийг тогтмол хийх;

2.2.10. мэргэшлийн зэрэг олгохтой холбоотой үйл ажиллагааны баримт бичгийг архивын хууль тогтоомжид заасны дагуу архивын нэгж үүсгэн хадгалах.

2.3. Мэргэжлийн нийгэмлэг, холбоо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.3.1. эрх авсан мэргэшлийн чиглэлээр шалгалт зохион байгуулах, 3 жилийн тасралтгүй сургалтын ерөнхий төлөвлөгөө гаргах, батлуулах, хэрэгжүүлэх;

2.3.2. төвийн захирлын баталсан төлөвлөгөөний дагуу мэргэшлийн зэргийн шалгалтыг зохион байгуулах;

2.3.3. эрх авсан мэргэшлийн чиглэлээрх хүний нөөцийн бүртгэл мэдээллийг хөтлөх, баяжуулах, дүн шинжилгээ хийх;

2.3.4. мэргэшлийн зэргийн шалгалт өгөх эрүүл мэндийн ажилтанд мэдээлэл, зөвлөгөө, давтлага өгөх;

2.3.5. мэргэжлийн нийгэмлэг, холбооны цахим хуудаст мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааны талаарх мэдээллийг байршуулах, тогтмол шинэчлэх, төвийн цахим хуудастай холбох;

2.3.6. мэргэшлийн зэргийн шалгалтын сорил, бодлогын сангийн нууцлалыг хангах;

2.3.7. Мэргэшлийн зэргийн шалгалтын комиссын гишүүнд санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтран баталсан багшийн ажлын хөлсний төлбөрийн жишигтэй дүйцүүлэн урамшуулал олгох;

2.3.8. мэргэшлийн зэргийн шалгалтын жил бүрийн тайланг шалгалт зохион байгуулснаас хойш ажлын 7 хоногт багтаан, үйл ажиллагааны 3 жилийн нэгдсэн тайланг тухайн жилийн 10 дугаар сарын 15-ны өдөрт багтаан төвд албан бичгээр хүргүүлэх;

2.3.9. мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааны жил бүрийн тайлан, 3 жилийн нэгдсэн тайлан, шалгалтын тэмдэглэл, хурлын тэмдэглэл, бусад бичиг баримтыг архивын хууль тогтоомжид заасны дагуу архивын нэгж үүсгэж хадгалах.

2.4. Эрүүл мэндийн байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.4.1. байгууллагын сургалт, ёс зүй, тусламж, үйчилгээний чанар, аюулгүй байдал, хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжийн төлөөлөл бүхий ажлын хэсгийг томилж, тухайн жилд мэргэшлийн зэргийн шалгалт өгөх хүсэлт гаргасан эрүүл мэндийн ажилтны асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, тодорхойлолт гаргах;

2.4.2. байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан нь эрүүл мэндийн ажилтны бичиг баримтын бүрдэлд хяналт тавьж, үнэн зөв байдлыг нягталж, мэдээллийг баталгаажуулан, жил бүрийн 3 дугаар сарын 20-ны өдөрт багтаан хүсэлтийг илгээх;

2.4.3. мэргэшлийн зэргийн нэмэгдэлд шаардагдах зардлыг тооцож, жил бүр улсын төсөвт тусгуулж, мэргэшлийн зэрэг олгох тухай шийдвэр гарсан өдрөөс эхлэн олгох;

2.4.4. мэргэшлийн зэргийн шалгалтын хугацаанд эрүүл мэндийн ажилтныг ажлаас чөлөөлөх дэмжлэг үзүүлэх.

2.5. Эрүүл мэндийн ажилтан нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- 2.5.1. өөрийн эзэмшсэн мэргэжил, мэргэшлийн чиглэлээр зэрэг зэрэг горилох тухай хүсэлтээ харьяалах байгууллагад гарган шийдвэрлүүлэх;
- 2.5.2. бүрдүүлсэн бичиг баримт, нотолгоо, тайлан, хүсэлтийн үнэн зөвийг бүрэн хариуцах;
- 2.5.3. мэргэшлийн зэргийн шалгалттай холбогдон гарах зардлыг батлагдсан зардлын жишгийн дагуу хариуцан төлөх;
- 2.5.4. Мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагаатай холбоотой санал, хүсэлт, гомдол гаргах.

Гурав. Мэргэжлийн нийгэмлэг, холбоонд тавигдах шаардлага

- 3.1 Мэргэшлийн зэргийн шалгалт зохион байгуулах мэргэжлийн нийгэмлэг, холбоо нь дараах шаардлагыг хангасан байна.
 - 3.1.1 улсын бүртгэлийн гэрчилгээтэй байх;
 - 3.1.2 сүүлийн 3-аас доошгүй жил үйл ажиллагаа тасралтгүй явуулсан байх;
 - 3.1.3 байнгын орон тоо бүхий нэгжтэй байх;
 - 3.1.4 тухайн мэргэжил, мэргэшлийн чиглэлээр тасралтгүй сургалт эрхлэх зөвшөөрөлтэй байх;
 - 3.1.5 тухайн мэргэжил, мэргэшлийн чиглэлээр олон улсын мэргэжлийн нийгэмлэгийн гишүүн байх.

Дөрөв. Шатлал, чиглэл, хугацаа, дүйцүүлэн тооцох

- 4.1 Мэргэшлийн зэрэг нь “ахлах”, “тэргүүлэх”, “зөвлөх” гэсэн 3 шатлалтай байна.
- 4.2 Шинээр зэрэг хамгаалах, шатлал ахих хугацаа тасралтгүй ажилласан 8 жил байна.
- 4.3 Мэргэшлийн зэргийг шатлал алгасуулан олгохгүй.
- 4.4 Дор дурдсан үндэслэлийг тасралтгүй ажилласан жилд оруулж тооцно:
 - 4.4.1 жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй;
 - 4.4.2 цэргийн жинхэнэ алба хаасан, энхийг сахиулах ажиллагаанд оролцсон;
 - 4.4.3 эрхтний донорын үүрэг гүйцэтгэсэн;
 - 4.4.4 гадаад улсад мэргэжил, мэргэшлээрээ суралцсан, магистр, докторын сургалтад хамрагдсан;
 - 4.4.5 удирдах дээд байгууллага, албан тушаалтны шийдвэрээр өөр ажил үүрэг гүйцэтгэсэн, төрийн байгууллагын сонгуульт үүрэг гурван сар хүртэл хугацаагаар гүйцэтгэсэн;
 - 4.4.6 төгсөлтийн дараах мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтад суралцсан;
 - 4.4.7 Өөрийн болон гэр бүлийн гишүүний биеийн эрүүл мэндийн байдлын улмаас мэргэжлээрээ ажиллахгүйгээр эмчлүүлж, сувилуулсан.
- 4.5 Эрүүл мэндийн ажилтан өөрийн хамгаалсан мэргэшлийн зэргээс бусад мэргэжил, мэргэшлийн чиглэлээр зэрэг горилох тохиолдолд өмнөх зэргийг тооцохгүй.
 - 4.5.1 Эрүүл мэндийн байгууллагын удирдлага, сургалт, эрдэм шинжилгээ,

хүний нөөц, статистик, мэдээлэл технологи, тусламж, үйлчилгээний чанарын чиглэлээр ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтны бусад чиглэлээр хамгаалсан мэргэшлийн зэргийг хүчинтэйд тооцно мөн тухайн албан тушаалтай холбоотой мэргэшлийн зэрэг ахиулахад бусад чиглэлээр хамгаалсан мэргэшлийн зэргийн шатлалаас ахиулж тооцно.

4.6 Орон нутагт ажилласан жилийг дараах байдлаар дүйцүүлэн тооцно:

4.6.1 сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвд тасралтгүй ажилласан 1 жилийг 1 жил 8 сараар дүйцүүлэх;

4.6.2 аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төвд тасралтгүй ажилласан 1 жилийг 1 жил 6 сараар дүйцүүлэх;

4.6.3 орон нутагт оношилгоо эмчилгээний шинэ технологи нэвтрүүлэх, төвлөрлийг сааруулах зорилгоор ажлын 5-аас доошгүй хоногоор ажилласан эрүүл мэндийн ажилтны хоног тутмыг 3 дахин нэмэгдүүлж тооцно:

4.6.3.1. аймаг, дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төвөөс сумын эрүүл мэндийн төвд ажилласан

4.6.3.2. төрөлжсөн, тусгай мэргэшлийн төвөөс аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, сумын эрүүл мэндийн төвд ажилласан

4.6.3.3. орон нутагт ажиллахад албажсан томилолттой байх, түүнийг бүртгэх мэдээний санг үүсгэх

4.7. Орон нутагт ажилласан жилийг зөвхөн нэг шатлалд дүйцүүлэн тооцно.

Тав. Шалгалтын агуулга, хэлбэр, үнэлгээ, комиссын бүрэлдэхүүн

5.1 Мэргэшлийн зэргийн шалгалтын агуулга нь тухайн эрүүл мэндийн ажилтны мэргэжил, мэргэшлийн мэдлэг, чадвар, хандлагыг бодитой үнэлэхүйц байх ба өмнөх шатлалын шалгалтын агуулгатай давхцаагүй, ахисан түвшний байна.

5.2 Мэргэшлийн зэргийн шалгалт нь сорил, бодлого, гардан үйлдэл (эмнэл зүйн орчин, дуураймал орчин, стандарт эмчлүүлэгч), ярилцлага, тайлан хамгаалалт гэсэн хэлбэртэй байна.

5.3 Мэргэшлийн зэргийн шалгалтыг танхим болон цахимаар зохион байгуулж болно.

5.4 Зөвлөх зэрэг болон дүйцүүлэн хамгаалах зэргийн шалгалтыг тайлан хамгаалалт хэлбэрээр зохион байгуулна.

5.5 Шалгалтын онолын шалгалтад 70 ба түүнээс дээш оноо авсан нөхцөлд дараагийн шатны шалгалтад орно.

5.6 Шалгалтын дундаж оноо 80 ба түүнээс дээш нөхцөлд тэнцсэнд тооцно.

5.7 Шалгалтын комиссыг холбогдох мэргэжлийн салбар зөвлөл, нийгэмлэг, холбоо, эмнэл зүйн сургагч багшийн төлөөллийг оролцуулж 5-аас доошгүй гишүүнтэйгээр жил бүр шинэчлэн байгуулна.

5.8 Комиссын бүрэлдэхүүний 2/3-оос доошгүй нь тухайн чиглэлийн мэргэшлийн зэрэгтэй эрүүл мэндийн ажилтан байна. Үүнд:

5.8.1 ахлах зэргийн шалгалтын комиссын 2/3-оос доошгүй нь тэргүүлэх

болон түүнээс дээш зэрэгтэй эрүүл мэндийн ажилтан, эмнэл зүйн сургагч багш, эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалтан болон 8-аас доошгүй жил ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтан;

5.8.2 тэргүүлэх зэргийн шалгалтын комиссын 2/3-оос доошгүй нь тэргүүлэх болон түүнээс дээш зэрэгтэй эрүүл мэндийн ажилтан, эмнэл зүйн сургагч багш, эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалтан болон 16-аас доошгүй жил ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтан;

5.8.3 зөвлөх зэргийн шалгалтын комиссын 2/3-оос доошгүй нь мэргэжил, мэргэшлээрээ 24 ба түүнээс дээш жил ажилласан тэргүүлэх ба түүнээс дээш зэрэгтэй эрүүл мэндийн ажилтан, эмнэл зүйн сургагч багш, эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалтан.

5.8.4 ёс зүйн харьцаа хандлага, мэргэжлийн ур чадварын манлайлалтай байх

Зургаа. Шалгалтын тов, гомдол шийдвэрлэх

- 6.1 Шалгалтыг жил бүрийн 03 дугаар сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдөрт багтаан зохион байгуулна.
- 6.2 Тухайн жилийн мэргэшлийн зэргийн шалгалтын төлөвлөгөөг 2 дугаар сарын 01-ний дотор төвийн захирлаар батлуулан нийтэд мэдээлж, хэрэгжилтийг ханган ажиллана.
- 6.3 Шалгалттай холбоотой дараах гомдлыг эрүүл мэндийн ажилтан ба бусад этгээдээс мэргэшлийн зэргийн шалгалт зохион байгуулсан комисст гаргаж, шийдвэрлүүлнэ.
- 6.4 Гомдол гаргагч нь бүртгэлтэй холбоотой гомдлыг бүртгэл дууссанаас хойш ажлын 3 хоногт, сорилын сан, шалгалтын явцад гарсан зөрчилтэй холбоотой гомдлыг шалгалт өгсөнөөс хойш ажлын 1 хоногт, үнэлгээтэй холбоотой гомдлыг шалгалтын дүнг зарласнаас хойш ажлын 2 хоногт багтаан, бусад гомдлыг шалгалт дууссанаас хойш 5 хоногийн дотор тус тус ирүүлнэ.
- 6.5 Гомдол гаргагч нь шалгалтын комиссын шийдвэртэй санал нийлэхгүй тохиолдолд Эрүүл мэндийн хөгжлийн төвд болон холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

Долоо. Зэргийн хүчинтэй хугацаа, хүчингүй болгох, нөхөн олгох

- 7.1 Мэргэшлийн зэрэг олгосноос хойш тухайн мэргэжил, мэргэшлээр тасралтгүй ажиллаж байгаа бүх хугацаанд хүчин төгөлдөр байна.
- 7.2 Энэхүү журмын 7.4.1, 7.4.2-д заасны дагуу мэргэшлийн зэрэг хүчингүй болгосон хугацаа нь эрүүл мэндийн ажилтны мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон хугацаатай ижил байна.
- 7.3 Шалгалт зохион байгуулах нийгэмлэг, холбооны эрхийг дараах тохиолдолд хүчингүй болгоно. Үүнд:
 - 7.3.1 мэргэшлийн зэргийн шалгалтыг хүндэтгэх шалтгаангүйгээр товлосон хугацаанд эхлүүлээгүй, дуусгаагүй;
 - 7.3.2 эрх олгоогүй чиглэлээр мэргэшлийн зэргийн шалгалт зохион байгуулсан;
 - 7.3.3 мэргэшлийн зэргийн шалгалтын үнэлгээний бодит байдалд шударга бус хандсан, ил тод байдал хангаагүй;
 - 7.3.4 мэргэжлийн нийгэмлэг, холбоо нь татан буугдсан буюу үйл

ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн;

7.3.5 өгсөн зөвлөмж, үүрэг даалгаврыг биелүүлээгүй;

7.3.6 мэргэшлийн зэргийн шалгалтын зардлын жишгийг үндэслэлгүйгээр нэмсэн.

7.4. Энэхүү журмыг зөрчсөн мэргэжлийн нийгэмлэг, холбоо, шалгалтын комисс, эрүүл мэндийн байгууллага, эрүүл мэндийн ажилтанд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.